



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 05 сарын 29 өдөр

Дугаар 6/20

Чингис хот

Б.Оргодолыг ажлаас чөлөөлөх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төрийн албаны тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1, 44.5 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.5, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Төрийн албаны зөвлөлийн даргын хамтарсан 2019 оны 34/31 дугаартай тушаалаар баталсан "Төрийн жинхэнэ албан хаагчийг өөр албан тушаалд шилжүүлэх, сэлгэн ажиллуулах журам"-ын 1.5, 1.6, 2.1, 5.1-т заасныг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн төсвийн ерөнхий нягтлан бодогч Б.Оргодолыг ажлын зайлшгүй шаардлагыг үндэслэн аймгийн Засаг даргын Тамгын газрын Төсвийн орлого, хөрөнгө оруулалтын санхүүжилт хариуцсан мэргэжилтний албан тушаалд шилжүүлэн ажиллуулах болсон тул 2020 оны 05 дугаар сарын 29-ний өдрөөр тасалбар болгон үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.

2. Ажил хүлээлцэх комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга:	С.Нямдаваа	Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга
Гишүүд:	Б.Онончимэг	Дотоод хяналт хариуцсан мэргэжилтэн
	Э.Ариунтунгалаг	Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч
	Т.Бямбадулам	Архив, бичиг хэргийн эрхлэгч
	Т.Баяртуяа	Аж ахуйн нярав

3. Б.Оргодолтой холбогдох тооцоог хийж дуусгахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч /Э.Ариунтунгалаг/-д даалгасугай

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА